



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөрөн сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/206/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 99900662 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn
Ахлах аудитор: Г. Эрдэнэчимэг
Утас: 99016320, Цахим хаяг: erdeneega@audit.gov.mn
Ньюбаланс Аудит ХХК-ийн захирал Б. Лхагвадорж
Утас: 99101901 Цахим хаяг: newbalance.lhagvaa@gmail.com
Чанарын хяналтын менежер Д. Гэрэлчулуун
Утас: 99509636.Цахим хаяг: d.gerlee98@gmail.com
Аудиторын туслах: Т. Мөнхгэрэл, Холбогдох утас: 99011389
Цахим хаяг: tumurmunkh08@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан	14
3.1 Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	18
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт.....	19
4.1 Залруулсан алдаа.....	Error! Bookmark not defined.
4.4 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
НА	Нягтлах ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120

Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/494
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Тавдугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Тавдугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>83,764,163.10</u>	<u>81,150,546.47</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
3121	Төгрөг	00.00	00.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	83,764,163.10	81,150,546.47
354	Хангамжийн материал	83,764,163.10	81,150,546.47
35420	Аж ахуйн материал	10,207,670.00	5,373,120.00
35440	Түлш, шатах тослох материал	2,000,000.00	1,275,000.00
35460	Хүнсний материал	6,293,440.00	8,133,069.30
35470	Бусад хангамжийн материал	65,263,053.10	66,369,357.17
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>793,387,221.97</u>	<u>696,790,870.13</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	793,387,221.97	696,790,870.13
392	Биет хөрөнгө	545,547,221.97	554,945,870.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	577,222,450.00	582,222,450.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-57,776,941.76	-81,479,212.64
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	48,200,221.00	60,828,162.08
39206	Хуримтлагдсан элэгдэл	-24,650,942.54	-10,995,784.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	2,473,113.00	5,518,461.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,269,077.73	-1,148,206.29
39217	Ном	2,348,400.00	00.00
393	Биет бус хөрөнгө	247,840,000.00	141,845,000.00
39301	Програм хангамж	795,000.00	1,155,000.00

Мөрөн сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

39302	Хуримтлагдсан элэгдэл	-795,000.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	247,840,000.00	140,690,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>877,151,385.07</u>	<u>777,941,416.60</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>1,153,300.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,153,300.00	00.00
413	Өглөг	1,153,300.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,153,300.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>875,998,085.07</u>	<u>777,941,416.60</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	875,998,085.07	777,941,416.60
512	Хуримтлагдсан үр дүн	-188,596,248.13	-286,652,916.60
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-98,056,668.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>877,151,385.07</u>	<u>777,941,416.60</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	556,122,360.00	534,011,033.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	496,611,260.00	532,152,233.93
120	Нийтлэг татварын бус орлого	8,506,060.00	24,984,333.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,506,060.00	24,984,333.93
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,506,060.00	24,984,333.93
121	Хөрөнгийн орлого	00.00	62,662,000.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	00.00	62,662,000.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	488,105,200.00	444,505,900.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	488,105,200.00	444,505,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	59,511,100.00	1,858,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	315,000.00	1,858,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,261,800.00

Мөрөн сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	315,000.00	597,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,196,100.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,196,100.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	549,617,021.08	519,974,812.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	549,617,021.08	519,974,812.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	515,516,676.61	519,530,150.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,636,900.00	340,644,600.00
210101	Үндсэн цалин	291,742,200.00	203,911,400.00
210102	Нэмэгдэл	25,516,100.00	111,354,600.00
210104	Урамшуулал	25,378,600.00	25,378,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,468,707.67	44,459,492.29
210201	Тэтгэврийн даатгал	28,662,999.12	30,833,592.29
210202	Тэтгэмжийн даатгал	3,660,608.55	3,406,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,972,000.00	2,725,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	743,100.00	681,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,430,000.00	6,812,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,745,774.86	54,240,569.27
210301	Гэрэл, цахилгаан	1,488,051.86	2,500,000.00
210302	Түлш, халаалт	45,290,980.00	47,696,100.00
210303	Цэвэр, бохир ус	6,966,743.00	4,044,469.27
2104	Хангамж, бараа материалын зардал	10,718,048.64	16,703,006.78
210401	Бичиг хэрэг	955,350.00	610,500.00
210402	Тээвэр, шатахуун	550,000.00	850,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	461,200.00	499,700.00
210404	Ном, хэвлэл	91,000.00	59,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,359,160.00	1,761,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,575,520.00	4,052,150.00

Мөрөн сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210408	Бараа материал акталсны зардал	2,725,818.64	8,869,656.78
2105	Нормативт зардал	26,214,257.00	13,868,487.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,811,101.00	1,099,900.00
210502	Хоол, хүнс	24,194,596.00	12,768,587.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	208,560.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,417,000.00	9,090,900.00
210604	Урсгал засвар	3,417,000.00	9,090,900.00
2107	Томилолт, зочны зардал	190,300.00	249,600.00
210702	Дотоод албан томилолт	190,300.00	249,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	620,000.00	3,619,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	270,000.00	2,899,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,505,688.44	36,653,895.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,436,000.00	2,662,360.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,421,250.00	3,825,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	29,648,438.44	30,165,634.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,100,344.47	444,661.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	90,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	90,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	389,130.71
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	389,130.71
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,650,325.14	55,530.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,650,325.14	55,530.73
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,360,019.33	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,360,019.33	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>6,505,338.92</u>	<u>14,036,221.53</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	229,045,159.40	112,092,890.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	21,514,500.00	2,348,400.00

225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	207,530,659.40	109,744,490.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-229,045,159.40	-112,092,890.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-222,539,820.48</u>	<u>-98,056,668.47</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1 дүгээр сарын 1-нээрх үлдэгдэл	128,199,142.00	185,641,915.00	-97,483,258.95	216,357,798.05
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	128,199,142.00	185,641,915.00	-97,483,258.95	216,357,798.05
C07	Тайлант үеийн үр дүн	247,840,000.00	00.00	26,325,988.34	274,165,988.34
C08	2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	376,039,142.00	688,555,191.20	-188,596,248.13	875,998,085.07
D01	2021 оны 1 дүгээр сарын 1-нээрх үлдэгдэл	376,039,142.00	688,555,191.20	-188,596,248.13	875,998,085.07
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	376,039,142.00	688,555,191.20	-188,596,248.13	875,998,085.07
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-98,056,668.47	-98,056,668.47
D09	2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	376,039,142.00	688,555,191.20	-286,652,916.60	777,941,416.60

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>547,616,300.00</u>	<u>509,026,700.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	467,688,200.00

Мөрөн сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

121	Хөрөнгийн орлого	00.00	55,990,600.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	00.00	55,990,600.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	00.00	411,697,600.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	00.00	411,697,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	547,616,300.00	41,338,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	488,105,200.00	32,808,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	315,000.00	1,858,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,261,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	315,000.00	597,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	59,196,100.00	6,671,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	59,196,100.00	6,671,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>547,616,300.00</u>	<u>509,026,700.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	547,616,300.00	509,026,700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	512,789,955.53	508,582,038.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	342,636,900.00	340,644,600.00
210101	Үндсэн цалин	291,742,200.00	203,911,400.00
210102	Нэмэгдэл	25,516,100.00	111,354,600.00
210104	Урамшуулал	25,378,600.00	25,378,600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,468,707.67	45,612,792.29
210201	Тэтгэврийн даатгал	28,662,999.12	31,986,892.29
210202	Тэтгэмжийн даатгал	3,660,608.55	3,406,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,972,000.00	2,725,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	743,100.00	681,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,430,000.00	6,812,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,795,774.86	53,515,569.27
210301	Гэрэл, цахилгаан	1,488,051.86	2,500,000.00

Мөрөн сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210302	Түлш, халаалт	45,340,980.00	46,971,100.00
210303	Цэвэр, бохир ус	6,966,743.00	4,044,469.27
2104	Хангамж, бараа материалын зардал	13,433,960.00	8,019,200.00
210401	Бичиг хэрэг	866,200.00	609,700.00
210402	Тээвэр, шатахуун	550,000.00	800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	501,200.00	499,700.00
210404	Ном, хэвлэл	251,000.00	249,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,359,160.00	1,761,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,906,400.00	4,098,300.00
2105	Нормативт зардал	35,346,813.00	17,997,577.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,000,101.00	1,099,900.00
210502	Хоол, хүнс	20,122,712.00	14,898,677.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,224,000.00	1,999,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,750,000.00	33,290,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,000,000.00	24,200,000.00
210604	Урсгал засвар	3,750,000.00	9,090,900.00
2107	Томилолт, зочны зардал	190,300.00	249,600.00
210702	Дотоод албан томилолт	190,300.00	249,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,594,500.00	3,619,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,294,500.00	2,899,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,573,000.00	5,632,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	753,000.00	1,636,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,820,000.00	3,995,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,826,344.47	444,661.44
2132	Бусад урсгал шилжүүлэг	816,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	816,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	389,130.71

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	389,130.71
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,650,325.14	55,530.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,650,325.14	55,530.73
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	32,360,019.33	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	32,360,019.33	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>00.00</u>	<u>00.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>00.00</u>	<u>00.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	507,167,900.00	506,723,238.56	444,661.4	99.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	507,167,900.00	506,723,238.56	444,661.4	99.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	507,167,900.00	506,723,238.56	444,661.4	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	340,644,600.00	340,644,600.00	0.0	100.0
210101	Үндсэн цалин	203,911,400.00	203,911,400.00	0.0	100.0
210102	Нэмэгдэл	111,354,600.00	111,354,600.00	0.0	100.0

Мөрөн сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210104	Урамшуулал	25,378,600.00	25,378,600.00	0.0	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,987,200.00	45,612,792.29	374,407.7	99.2
210201	Тэтгэврийн даатгал	32,361,300.00	31,986,892.29	374,407.7	98.8
210202	Тэтгэмжийн даатгал	3,406,500.00	3,406,500.00	0.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,725,200.00	2,725,200.00	0.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	681,300.00	681,300.00	0.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,812,900.00	6,812,900.00	0.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,571,100.00	53,515,569.27	55,530.7	99.9
210301	Гэрэл, цахилгаан	2,500,000.00	2,500,000.00	0.0	100.0
210302	Түлш, халаалт	46,971,100.00	46,971,100.00	0.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	4,100,000.00	4,044,469.27	55,530.7	98.6
2104	Хангамж, бараа материалын зардал	6,547,400.00	6,547,400.00	0.0	100.0
210401	Бичиг хэрэг	399,700.00	399,700.00	0.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	800,000.00	0.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	499,700.00	499,700.00	0.0	100.0
210404	Ном, хэвлэл	249,700.00	249,700.00	0.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	1,000,000.00	0.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,598,300.00	3,598,300.00	0.0	100.0
2105	Нормативт зардал	18,012,300.00	17,997,577.00	14,723.0	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,099,900.00	1,099,900.00	0.0	100.0
210502	Хоол, хүнс	14,913,400.00	14,898,677.00	14,723.0	99.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,999,000.00	1,999,000.00	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,290,900.00	33,290,900.00	0.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,200,000.00	24,200,000.00	0.0	100.0
210604	Урсгал засвар	9,090,900.00	9,090,900.00	0.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	249,600.00	249,600.00	0.0	100.0

210702	Дотоод албан томилолт	249,600.00	249,600.00	0.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,619,600.00	3,619,600.00	0.0	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,899,600.00	2,899,600.00	0.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00	0.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5245200.00	5245200.00	0.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,249,300.00	1,249,300.00	0.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,995,900.00	3,995,900.00	0.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	507,167,900.00	506,723,238.56	444,661.4	99.9
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	444,505,900.00	444,116,769.29	389,130.7	99.9
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	444,505,900.00	444,116,769.29	389,130.7	99.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	62,662,000.00	62,606,469.27	55,530.7	99.9
132001	Орон нутгийн төсвөөс	62,662,000.00	62,606,469.27	55,530.7	99.9
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	28.00	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	0.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	0.0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28.00	28.00	0.0	100.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	15.00	15.00	0.0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13.00	13.00	0.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,858,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,858,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,858,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,471,800.00
210401	Бичиг хэрэг	210,000.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	761,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	387000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	387,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1858800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,858,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,261,800.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	597,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөрөн сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ньюбаланс Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Лхагвадорж, аудиторын туслах Т.Мөнхгэрэл нар гүйцэтгэж, хяналтыг Ньюбаланс Аудит ХХК-ийн аудитын чанарын хяналтын менежер Д.Гэрэлчулуун, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Мөрөн сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ньюбаланс Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мөрөн сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэг нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалтын үйл ажиллагаа эрхлэх улсын төсвийн байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоол батлагдан, мөн Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолын хавсралт

ёсоор баталсан шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг өөрчилсөн, "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг хавсралтаар шинэчлэн батлах тухай Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөрөн сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 549.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоосон болно.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөрөн сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 99.2 сая төгрөгөөр буурсан нь эрх бүхий этгээдийн шийдвэрээр тус байгууллагаас биет бус хөрөнгө шилжүүлэн, шинээр хүүхдийн цэцэрлэг байгуулсантай холбоотой байна. Тайлант онд мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.00	0.00	0.00
Бараа материал	83,764,163.10	81,150,546.47	-2,613,616.63
Биет хөрөнгө	545,547,221.97	554,945,870.13	9,398,648.16

Биет бус хөрөнгө	247,840,000.00	141,845,000.00	-105,995,000.00
Нийт хөрөнгө	877,151,385.07	777,941,416.60	-99,209,968.47
Дансны өглөг	1,153,300.00	0.00	-1,153,300.00
Засгийн газрын хувь оролцоо	875,998,085.07	777,941,416.60	-98,056,668.47
Хуримтлагдсан үр дүн	-188,596,248.13	-286,652,916.60	-98,056,668.47
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	877,151,385.07	777,941,416.60	-99,209,968.47

Тайлант хугацаанд авлага, өглөгийн дансны үлдэгдэлгүй болно.

Бараа материалын дансны үлдэгдэл 81.1 сая төгрөг болж, 2.6 сая төгрөгөөр буурсан нь аж ахуйн материалын нөөц буурсантай холбоотой байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн “Үндсэн хөрөнгө худалдах, шилжүүлэх, актлах тухай” 18 дугаар тогтоолыг үндэслэн 107.2 сая төгрөгийн бусад биет бус хөрөнгө буюу газрыг данснаас хасаж, шилжүүлсэн.

Үндсэн хөрөнгийн машин тоног төхөөрөмжийн данснаас 4.4 сая төгрөгийн хөдлөх хөрөнгийг Мөрөн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх, ашиглах жил болон үнийг шинэчлэн тогтоох тухай” 39 дүгээр тогтоолыг үндэслэн акталж, данснаас хассан байна.

Мөн Мөрөн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн “Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх, ашиглах жил болон үнийг шинэчлэн тогтоох тухай” 39 дүгээр тогтоолыг үндэслэн машин тоног төхөөрөмжийн данснаас 15.7 сая төгрөгийн хөдлөх хөрөнгийг дахин үнэлж, 5.0 сая төгрөгийн үнэтэйгээр орлогод авч, бүртгэсэн.

Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б. Должинсорогдогийн гарын үсэг бүхий 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 1/1216 тоот албан бичгийн дагуу 20.7 сая төгрөгийн үнэтэй 4 нэр төрлийн цахим сургалтад шаардагдах техник хэрэгсэл худалдан авсан нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” Монгол Улсын хууль, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолын хавсралт ёсоор баталсан шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарт нийцээгүй боловч гүйцэтгэгч сонгон шалгаруулах харьцуулалтын аргыг хэрэглэн, худалдан авалт хийсэн байна.

Биет бус хөрөнгөд бүртгэлтэй нягтлан бодох бүртгэлийн программыг 2012 онд, няравын бүртгэлийн программыг 2014 онд тус тус бүртгэн авсан ба 4 жилээр элэгдэл байгуулан ашигласан боловч одоо дахин үнэлэгдсэн үлдэгдэл өртөг нь 1.1 сая төгрөг болсон. Биет хөрөнгийн дүн 554.9 сая төгрөг болж, 9.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд байгуулсан элэгдлийн дүн, 24.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй хөрөнгө дансанд нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо данс 777.9 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн -286.6 сая төгрөг, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 688.6 сая төгрөг байна.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 534.0 сая төгрөг, нийт зардал 520.0 сая төгрөг ба тайлант үеийн үр дүн 14.0 сая төгрөг байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд тайлант хугацааны үр дүн -98.0 сая төгрөгөөр нөлөөлж, нийт цэвэр өмчийн дүн 777.9 сая төгрөг байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Мөрөн сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 532.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 532.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 534.7 сая төгрөгийн төсөв баталжээ.

Тухайн төсвийн жилд төсөвт 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу 1 удаа төсвийн тодотгол, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн “Төсөвт зохицуулалт хийх тухай” А/281 дүгээр захирамж, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн “Төсөвт зохицуулалт хийх тухай” А/608 дугаар захирамж, Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн “Аймгийн 2021 оны төсөвт тодотгол хийх тухай” 01 дүгээр тогтоолоор нийт 3 удаа төсвийн зохицуулалт хийсэн. Тайлант жилийн онцгой нөхцөл байдлаас үүдэн хоол хүнсний зардлаас 21.0 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 4.3 сая төгрөг, бусад тээвэр, шатахуун, томилолт, зочны зардлаас нийт 27.5 сая төгрөгийг хассан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Мөрөн сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэг тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 зориулалт, арга хэмжээг санхүүжүүлэхээр 534.7 сая төгрөгийн төсөв баталснаас 472.7 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 444.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 62.7 сая төгрөгийн санхүүжилт авч, нийт 534.0 сая төгрөгийн орлого (үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө орсон) бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 520.0 сая төгрөгийг зарцуулж, 0.4 сая төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 506.7 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 0.4 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулсны үр дүнд 27.5 сая төгрөгийн хэмнэлт гаргаж, 10 хувиас доошгүй хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Нийт төсвийн зардлыг 1 хөтөлбөрийн 3 зориулалт, арга хэмжээнд 0.4 сая төгрөгөөр дутуу зарцуулсан.

71801 буюу сургуулийн өмнөх боловсрол хөтөлбөрийн хүрээнд 3 зориулалт, арга хэмжээнд зарцуулсан гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлбэл :

Хөтөлбөр	Зориулалт, арга хэмжээний код	Арга хэмжээний нэр	Төсөв	Гүйцэтгэл	зөрүү	Тайлбар
71801- СӨБ	81834	Боловсролын стандарт сургалтын	261.9	261.5	0.3	төвлөрүүлсэн

		төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх				
71801- СӨБ	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	182.6	182.6		
71801- СӨБ	80109	Тогтмол зардал	62.7	62.6	0.1	төвлөрүүлсэн
Дүн			507.2	506.7	0.4	төвлөрүүлсэн

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна.” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Мөрөн сумын хүүхдийн 5 дугаар цэцэрлэг тайлант онд төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 0.6 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийн орлого 1.3 сая төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлсэн. Уг хөрөнгийн эх үүсвэрээс бичиг хэргийн зардалд 0.2 сая төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардалд 0.8 сая төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлсийн зардалд 0.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 0.4 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал:

Үүнд: Коронавирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, орон нутагт малын гоц халдварт өвчинтэй тэмцэх гэх мэт үйл ажиллагаа нь онцлог асуудал байна.

Цар тахлын үеийн хөл хорио тавих хариу арга хэмжээнээс үүдэн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаа хэвийн бус явагдаж, өдөрт хамран суралцах хүүхдийн тоо төлөвлөсөн 200-аас буурч, хамгийн ихдээ 106 хүүхэд хамрагдсан нь хоол, хүнсний зардлыг төсвийн тодотголоор бууруулан батлах үндэслэл болсон байна. Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Мөрөн сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь Засгийн газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж, 27.5 сая төгрөгийн хэмнэлт гаргасан байна. Оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлээр гарсан хэмнэлт болох 27.5 сая төгрөгийг төсвийн тодотголоор хасаж, сүүлийн хагас жилд гарсан 21.2 сая төгрөгийн хэмнэлтийг

зохицуулан шийдвэрлэж, цахим сургалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авсан байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолын хавсралт ёсоор баталсан шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарт тус тус нийцсэн гэж дүгнэлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих 506.7 сая төгрөгийн 65 мэдээллээс 506.7 сая төгрөгийн 65 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн зарим захиргааны хэм хэмжээний актын нийцлийн хэрэгжилтийг хянан үзлээ. Үүнд: Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолын хавсралт ёсоор баталсан шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарт тус тус нийцсэн эсэхийг дүгнэн үзсэн болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бусдаар гүйцэтгүүлэх зардлаас 1.9 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, үйлчилгээний хөлс төлснийг анхааруулж, зөвлөмж өгснийг дахин хянахад зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг ажиглалт, тооллого хийх горим, сорилын аргыг хэрэглэн, аудит хийхэд анхаарах нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй бөгөөд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажилласан байна.

Мөрөн сумын Хүүхдийн 5 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС
ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

[Handwritten signature]
[Handwritten signature]
[Handwritten signature]
1721 00001 3070605

А.ЭРДЭНЭБААТАР
Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Э.БАТ-ЭРДЭНЭ
Огноо: 9/25

АХЛАХ АУДИТОР:

Г.ЭРДЭНЭЧИМЭГ
Огноо: 2/24

НЬЮБАЛАНС АУДИТ ХХК-ИАС
ХЯНАСАН:

ЗАХИРАЛ

[Handwritten signature]

Б.ЛХАГВАДОРЖ
Огноо:

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОРЫН ТУСЛАХ

[Handwritten signature]
9/24

Т.МӨНХГЭРЭЛ
Огноо: